



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/56

Чойр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, Аймгийн Онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар “Ковид-19”-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажлын хүрээнд шуурхай штабын холбоо, интернет, бичиг хэргийн зардал болон боловсролын байгууллагын багш, ажилчид, сурагчдын тандалт шинжилгээнд шаардлагатай түргэвчилсэн оношлуур, явуулын сурталчилгаа хийх шатахууны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2.Холбогдох арга хэмжээнд шаардагдах 957,400 (есөн зуун тавин долоон мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д, 5,092,020 (таван сая ерэн хоёр мянга хорин) төгрөгийн бараа материалыг аймгийн Нөөцийн бараа материалаас тус тус гаргахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, онцгой комиссын орлогч дарга (хурандаа Х.Сүхбаатар)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 02...  
 дугаар сарын 22-ний өдрийн 1/56  
 дугаар захирамжийн хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ  
 БУУРУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

<b>ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС</b>					
№	Материалын нэр	хэмжих нэгж	тоо хэмжээ	нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шуурхай штабын холбооны зардал /1-4 сарын төлбөр/	ш	4	130,000	520,000
2	Шуурхай штабын интентийн төлбөр	ш	6	42,900	257,400
3	Бичгийн цаас	боод	5	14,000	70,000
4	Архивын бор цаас	ш	25	1,000	25,000
5	Баримтын хайрцаг	ш	10	3,500	35,000
6	Утас	ш	1	3,500	3,500
7	Баримтын наалт	ш	2	2,500	5,000
8	Цэнхэр хавтас	ш	5	4,500	22,500
9	Нүхтэй хавтас	ш	2	9,500	19,000
<b>ДҮН</b>					<b>957,400</b>
<b>АЙМГИЙН НӨӨЦИЙН БАРАА МАТЕРИАЛААС</b>					
1	Шатахууны талон	л	42	2,310	97,020
2	Түргэвчилсэн оношлуур /хамар залгуурын тест/	ш	600	8,325	4,995,000
<b>ДҮН</b>					<b>5,092,020</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>6,049,420</b>